



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар Б/46

Хэрлэн сум

**С.Сарангоог ажилд жинхлэн
томилох тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 43 дугаар зүйлийн 43.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2024 оны “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай” 82 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, зохион байгуулалт хариуцсан ажилтны албан тушаалд тавигдах шаардлагыг хангаж байгаа тул Сарантуяагийн Сарангоогийн туршилтын хугацааг дуусгавар болгож, 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс ажилд жинхлэн томилсугай.

2. С.Сарангоогийн сарын үндсэн цалинг ТҮ-7 зэрэглэлээр тогтоон, 1,264,000 (нэг сая хоёр зуун жаран дөрвөн мянга) төгрөгөөр тооцож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 3 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг С.Сарангоод үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА

231030136